

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2024 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ З.БАДРАЛ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/249  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд их засварын 11 ажилд 640.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 8 ажилд 523.6 сая төгрөг, техник зохион байгуулалтын 13 ажилд 111.5 сая төгрөг нийт 1,275.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийсэн байна.

#### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 354.3 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, анхан шатны баримтын бүрдэлгүй болон үр ашиггүй зарцуулсан 30.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

#### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал нь Төлөөлөн Удирдах зөвлөлөөр бизнес төлөвлөгөөгөө батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6724040598


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	266,790,934.66	81,224,795.97
1.1.2	Дансны авлага	882,495,076.43	687,232,730.67
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	85,278,945.93	1,282,918.32
1.1.6	Бараа материал	459,635,355.51	488,001,348.38
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,694,200,312.53</b>	<b>1,257,741,793.34</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,833,172,399.50	29,219,578,870.80
1.2.2	Биет бус хөрөнгө	657,405,852.18	656,270,832.35
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>29,490,578,251.68</b>	<b>29,875,849,703.15</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,184,778,564.21</b>	<b>31,133,591,496.49</b>
2.1.1.1	Дансны өглөг	1,984,608,966.11	1,775,665,355.31
2.1.1.3	Татварын өр	0.00	42,895,240.33
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	42,160,156.76	42,993,875.67
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,026,769,122.87</b>	<b>1,861,554,471.31</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,008,466,164.46	871,670,464.46
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,008,466,164.46</b>	<b>871,670,464.46</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,035,235,287.33</b>	<b>2,733,224,935.77</b>
2.3.1	Төрийн өмч	16,800,000,000.00	16,800,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,831,501,384.55	7,831,501,384.55
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,317,866,421.53	8,732,310,253.97
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-4,799,824,529.20	-4,963,445,077.80
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>28,149,543,276.88</b>	<b>28,400,366,560.72</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>31,184,778,564.21</b>	<b>31,133,591,496.49</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>13,307,103,605.04</b>	<b>17,279,239,414.73</b>
2	Борлуулалтын өртөг	13,205,693,291.50	15,443,954,754.64
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>101,410,313.54</b>	<b>1,835,284,660.09</b>
5	Хүүгийн орлого	0.00	404,299.10
8	Бусад орлого	257,241,896.60	417,660,908.89
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,202,796,465.04	1,775,603,783.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	199,082,890.51	175,895,704.21
12	Бусад зардал	204,547,061.71	438,617,943.24
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-3,956,141.03	-21,850,302.12
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>-1,251,730,348.15</b>	<b>-158,617,864.94</b>
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>-1,251,730,348.15</b>	<b>-158,617,864.94</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>-1,251,730,348.15</b>	<b>-158,617,864.94</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-3,548,094,181.05	29,401,273,625.03
3	Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-3,548,094,181.05	29,401,273,625.03
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	-1,251,730,348.15	-1,251,730,348.15
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	7,831,501,384.55	-	-	7,831,501,384.55
1	Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-4,804,827,212.86	28,144,540,593.22
1	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	347,958,131.59	-	347,958,131.59
1	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	-158,617,864.94	-158,617,864.94
1	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	7,831,501,384.55	-	-	7,831,501,384.55
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,732,310,253.97	-4,963,445,077.80	28,400,366,560.72

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,455,860,759.53	14,912,018,872.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,416,266,574.79	14,866,769,265.31
1.1.6	Бусад мөнгөн орлого	39,594,184.74	45,249,606.78
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,212,945,374.89	14,927,192,650.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,113,732,438.95	1,559,916,995.02
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	529,939,913.81	725,722,794.69
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	805,046,992.98	933,284,998.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	8,917,436.93	5,312,595.20
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,032,703,302.94	10,650,601,312.30
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	14,166,548.78	6,362,941.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	390,484,668.54	526,862,167.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	10,083,171.00	9,584,975.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	307,870,900.96	509,543,870.74
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	242,915,384.64	15,173,778.69
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	404,299.10
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	404,299.10
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	238,549,723.18	34,297,959.10
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	238,549,723.18	34,297,959.10
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(238,549,723.18)	33,893,660.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	136,795,700.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	136,795,700.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	136,795,700.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,365,661.46	185,863,138.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	262,425,273.20	266,790,934.66
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	266,790,934.66	81,224,795.97

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Зардлын төрөл	/мян.төгрөг/		
		Тайлант оны		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
		1	2	1-2
1	Борлуулалтын орлого	12,035,000.0	11,944,206.6	90,793.4
2	Түгээх үйлчилгээний орлого	5,335,032.8	5,335,032.8	-
3	Бусад орлого	350,000.0	418,065.2	(68,065.2)
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>17,720,032.8</b>	<b>17,697,304.6</b>	<b>22,728.2</b>
1	Шатахууны зардал	126,363.4	126,156.8	206.6
2	Тээврийн зардал	4,704.5	4,909.1	(204.6)
3	Сэлбэг хэрэгсэл	99,726.7	101,490.8	(1,764.1)
4	Урсгал засвар	153,012.0	154,344.5	(1,332.5)
5	Материал, хангамжийн материал	4,305.5	4,302.7	2.8
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	2,560,243.3	2,500,965.9	59,277.4
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	390,330.3	383,284.9	7,045.4
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	52,669.2	52,580.6	88.6
9	Ашиглалтын зардал-Дулаан	60,298.8	60,108.7	190.1
10	Ашиглалтын зардал-Ус	4,550.0	3,731.0	819.0
11	Албан томилолтын зардал	115,642.4	115,513.3	129.1
12	Конторын хангамжийн зардал	15,561.2	15,343.6	217.6
13	Харилцаа холбооны зардал	6,484.3	6,403.7	80.6
15	Хөдөлмөр хамгааллын зардал	155,327.6	158,285.2	(2,957.6)
16	Даатгалын зардал	10,457.1	9,585.0	872.1
17	Галын аюулаас хамгаалах зардал	1,076.2	1,076.2	-

18	Гүйцэтгэх удирдлагын зардал	58,758.1	58,842.2	(84.1)
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	75,631.3	75,604.5	26.8
20	Борлуулалт, маркетингийн зардал	35,322.1	36,477.6	2,244.5
21	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	13,468.9	13,202.5	266.4
22	Гаднын үйлчилгээний хөлс	70,016.6	72,710.2	(2,693.6)
24	Сургалтын зардал	13,840.4	11,709.3	2,131.1
		<b>4,027,789.9</b>	<b>3,966,628.1</b>	<b>64,561.8</b>
<b>25</b>	<b>Элэгдлийн зардал</b>	<b>1,581,900.8</b>	<b>1,476,813.6</b>	<b>105,087.2</b>
	Үүнээс: Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		40,374.0	(40,374.0)
	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	1,581,900.8	1,436,439.6	145,461.2
<b>26</b>	<b>Орлогын албан татвараас бусад татвар</b>	<b>15,035.2</b>	<b>12,391.8</b>	<b>2,643.4</b>
	Үүнээс: Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,273.6	7,194.1	1,079.5
	АТӨЯХ-ийн албан татвар	999.1	1,176.2	(177.1)
	Газрын төлбөр	5,762.5	4,021.5	1,741.0
27	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	143,158.7	6,362.9	136,795.8
29	Бусад	300,000.0	311,402.1	(11,402.1)
30	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	21,850.3	(21,850.3)
31	Ажиллагсдын нийгмийн зардал	358,154.7	358,149.3	5.4
	<b>Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн</b>	<b>801,313.4</b>	<b>697,764.7</b>	<b>136,801.1</b>
	<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>6,426,039.3</b>	<b>6,153,598.3</b>	<b>309,093.5</b>
33	Худалдаж авсан ЦЭХ-ний төлбөр	11,442,200.0	11,575,108.4	(132,908.4)
	<b>Нийт Үндсэн ҮА-ны зардал</b>	<b>17,868,239.3</b>	<b>17,728,706.7</b>	<b>176,185.1</b>
	Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн	350,000.0	127,215.8	222,784.2
	<b>НИЙТ ЗАРДАЛ /37+40+43/</b>	<b>18,218,239.3</b>	<b>17,855,922.5</b>	<b>398,969.3</b>
37	<b>Нийт ашиг/алдагдал /48-44/</b>	<b>(498,206.5)</b>	<b>(158,617.9)</b>	<b>(376,241.1)</b>

## 5. Аудитын илрүүлэлт

5.1 Аудитаар нийт 354.3 сая төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залрууллаа. Үүнд:

1. Техникийн нөхцөл олгохтой холбоотой 5.0 сая төгрөгийн борлуулалт болон авлагыг дутуу тайлагнасан алдааг залруулсан.
2. Компанийн эзэмшил дэх заалны түрээсийн орлогыг 17.0 сая төгрөг, зарцуулалт 17.0 сая төгрөгийг бүртгээгүй алдааг залруулсан.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн 237.1 сая төгрөгийг үндсэн хөрөнгийг бүртгээгүй байсныг залруулсан.
4. Компанийн эзэмшилд байсан автомашиныг шилжүүлэхдээ үлдэгдэл өртөг 21.9 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар хүлээн зөвшөөрөөгүй байсныг залруулсан.
5. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 40.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг залруулсан.
6. Бараа материалын үлдэгдлийг 9.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг залруулсан.
7. Бүртгэлд 0.7 сая төгрөгийн өглөг, 5.7 сая төгрөгийн авлагыг зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 537.7 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 30.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 507.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 9 зөвлөмж өгсөн.

### 5.2 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд:

1. Шатахууны нормыг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Анхан шатны баримтын бүрдэлгүй 0.2 сая төгрөгийн томилолтын зардал санхүүжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Компанийн аварга шалгаруулах тэмцээний шагнал гэж гүйцэтгэх захирлын тушаалаар 2.7 сая төгрөг зарцуулсан байна. Уг шагналыг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, ашиглалтын албаны дарга нар авсан байна. Ямар тэмцээн зохион байгуулсан нь тодорхойгүй, удирдамж зэрэг нотлох баримтгүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийн хангахгүй байна.
  4. Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан компанийн ажилчдад 1.1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Урамшуулал олгохдоо хүчингүй болсон журмын заалтыг үндэслэл болгосон байна.
  5. Компанийн эзэмшилд байх спорт заалны түрээсийн орлогоос 7.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр, зориулалт бус зардалд зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. гэсэн заалттай тус тус нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  6. Байгууллагын төсвөөс 0.7 сая төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  7. Хөвсгөл аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн 938 дугаар шийдвэрээр Ц.Энхбаярт 3.2 сая төгрөг, 2021 оны 06 сарын 14-ний өдрийн 155/ШШ2021/00638 дугаар тушаалаар В.Чулуунд 4.2 сая төгрөгийг тус тус олгосон ба тус мөнгийг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх зөвлөмжийг тайлант онд хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." гэсэн заалттай нийцэхгүй байна
  8. 2023 оны жилийн эцэст байгууллагын ажиллагсдын дунд болзолт уралдаан зарлаж, шагналын зардалд 36.0 сая төгрөг зарцуулсан ба үүнээс 10.0 сая төгрөгийг холбогдох албан хаагчдад хүлээлгэн өгсөн баримт үйлдээгүй байна.

### 5.3 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчлүүдэд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

#### **1. Компанийн хамтын гэрээтэй холбоотой:**

##### 1.1 Илрүүлэлт:

Байгууллагын хамтын гэрээнд хууль тогтоомжид нийцэхгүй дараах заалтууд байна. Үүнд:

- a. Хамтын гэрээний 3.18 дахь заалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.6 дахь заалттай,
- b. Хамтын гэрээний 5.13 дахь заалт нь 82.1 дэх заалттай нийцэхгүй,
- c. Хамтын гэрээний 3.11 дэх заалт нь Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалын 5.3 дахь заалттай нийцэхгүй,
- d. Хамтын гэрээний 5.19 дэх заалт нь Төсвийн тухай хуулийн 46.3 дахь заалттай нийцэхгүй,
- e. Хамтын гэрээний 5.18 дахь заалт нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалттай нийцэхгүй,
- f. Хамтын гэрээний 5.31 дэх заалт нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь тус тус нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2 Өгсөн албан шаардлага:

Хамтын гэрээг холбогдох хууль эрх зүйд нийцүүлэн боловсруулж батлуулан, мөрдөж ажиллах

## 2. Худалдан авах ажиллагаатай холбоотой:

### 2.1 Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 214.9 сая төгрөг, үүнээс анхан шатны баримтын бүрдэл дутуу, бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй 60.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Шатахууны зардлыг гэрээний үнээс 33.9 сая төгрөгөөр, авто сэлбэгийн зардлыг 116.5 сая төгрөгөөр хэтрүүлэн тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "*Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ*" гэж заасныг зөрчсөн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 2.2 Өгсөн албан шаардлага:

Худалдан авах ажиллагааг хууль журамд нийцүүлэн төлөвлөж, зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох

## 3. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой

### 3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7. аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах; Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-тай тус тус нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Өгсөн албан шаардлага:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох

## 4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

### 4.1 Илрүүлэлт:

- Ухаалаг тоолуурын зардлыг гэрээний үнээс 29.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- Мэйжүрмэнт ХХК-аас И-Баримтаар нийт 141.7 сая төгрөгийн худалдан авалт бүртгэсэн байхад гүйцэтгэлээр 94.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон, өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн авлага 5.7 сая төгрөг бүртгэсэн байна.
- Зах зээлийн үнээс өндөр үнээр ухаалаг тоолуур худалдан авсан, үнэ төлбөргүй суурилуулах ухаалаг тоолуурыг дамжуулан борлуулсан, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй, ашгийн бус үйл ажиллагааг бүртгэлд тусгаж, тайлагнасан байна.

### Өгсөн албан шаардлага:

Компанид хамааралгүй борлуулалт болон өглөг авлагыг бүртгэхгүй байх, үнэ төлбөргүй суурилуулж буй ухаалаг тоолуурыг дамжуулан борлуулж буй зөрчлийг таслан зогсоох

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Төлөөлөн Удирдах зөвлөлд:

##### 1. Бүтэц орон тоотой холбоотой

###### 1.1. Илрүүлэлт:

Тайлант онд компанийн бүтэц, орон тоог 4 удаа өөрчлөн баталсан байна. Энэ нь компанийн хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх болон ашиг сонирхол бий болгох эрсдэлийг үүсгэж байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Компанийн бүтэц орон тоог тогтвортой байхаар батлах

**2. *Нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой***

**1.1 Илрүүлэлт:**

ТУЗ-ын хурлын тэмдэглэлийг татан авч шалгахад 2023.12.05 өдрийн тэмдэглэл үйлдээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3-т "хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарч буй шийдвэр, тэмдэглэлийг хугацаанд нь хөтөлж, баримтжуулах

***Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч, холбогдох ажилтнуудад:***

**3. *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой***

**1.1 Илрүүлэлт:**

Татварын э-баримт системд борлуулалтыг 3,258.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; 20.2.7.аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах; гэсэн заалттай тус тус нийцэхгүй, "тасалбар болголт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Мөн энэ компанийг 325.8 сая төгрөгийн НӨАТ-ийн өр төлбөрт оруулах эрсдэлийг үүсгэж байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Давхардсан орлогыг системд залруулж бүртгэх

**4. *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой***

**4.1 Илрүүлэлт:**

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн дансны код нь /Борлуулсан бүтээгдэхүүний өртөг/ Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт болон байгууллагын НБББББ-тэй нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2 Өгсөн зөвлөмж:**

Дансны кодыг журамд нийцүүлэн шинэчлэх

**5. *Бүтэц, орон тоотой холбоотой***

**1.1 Илрүүлэлт:**

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөл нь компаниас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн бүтэц орон тоонд 4 удаа өөрчлөлт хийсэн байна. Шинээр 2 орон тоо нэмсэн ба бүтцийн өөрчлөлтөөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах инженер, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Татварын бүртгэл хариуцсан нягтлан бодогч, мөнгөн хөрөнгийн касс гэсэн ажлын байруудыг шинээр нэмж үүсгэсэн байна. Компанийн бүтэц орон тоог өөрчлөн зохион байгуулж байгаа компаниас бүтцийг оновчтой төлөвлөхгүй байгаатай холбоотой байгаа ба компанийн хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.

**5.2 Өгсөн зөвлөмж:**

Компанийн бүтэц орон тоог оновчтой төлөвлөж, батлагдсан бүтэц орон тоог тогтвортой баримталж ажиллах

**6. *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой***

### 6.1 Илрүүлэлт:

Дотоод хяналтын албаны ажилтан нь тайлант онд хийх хяналт, шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулж эрх бүхий ажилтнаар батлуулаагүй байна. Мөн тайлант онд хийсэн хяналт шалгалтын ажлын тайлантай танилцахад байгууллагын дотоод журам боловсруулалт, сумдын цахилгаан дамжуулалттай холбоотой үзлэг шалгалт зэргийг хийж ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4. *Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.*, 4.1. *Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна:* гэсэнтэй тус тус нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 6.2 Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, компанийг эрсдэлээс хамгаалах

## **7. Хамтын гэрээтэй холбоотой**

### 7.1 Илрүүлэлт:

Байгууллага нь ахмадын сан байгуулж ажиллагаагүй, Хамтын гэрээний 3.11, 5.4, 5.7, 5.12, 5.14, 5.15, 5.22, 5.23, 5.24, 6.11 дэх заалтуудаар ахмад настны нийгмийн баталгаа болон нэг удаагийн шинжтэй тэтгэмж урамшууллыг байгууллагын төсвөөс зарцуулахаар хамтын гэрээнд тусгасан байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-д нийцэхгүй, Хамтын гэрээний 5.25-д "Байгууллага нь "Ахмад настны тухай хууль"-д заасны дагуу ахмадын сан байгуулж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 7.2 Өгсөн зөвлөмж:

Хуульд заасны дагуу ахмадын сан байгуулж, холбогдох зардлуудыг тус сангаас зарцуулах

## **8. Худалдан авах ажиллагаатай холбоотой**

### 8.1 Илрүүлэлт:

Ханх сумын ЦДАШ-н шинэчлэлтийн ажилд шаардлагатай 10КВ-н СИП-3, ЦДАШ тоноглол худалдан авах 2 тендерийг хянан үзэхдээ 2024.01.01-ээс мөрдөж эхлэх шинэчилсэн найруулгын заалтыг үндэслэн "Арилеон" ХХК-н ирүүлсэн тендерээс татгалзсан байна.

### 8.2 Өгсөн зөвлөмж:

Тендерийг хянан үзэхдээ хүчин төгөлдөр хууль эрх зүйн заалтыг мөрдлөг болгох

## **9. Худалдан авах ажиллагаатай холбоотой**

### 9.1 Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс зайлсхийж, 70 сая төгрөгөөс ялимгүй доогуур дүнгээр төсөв баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 9.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг журамд нийцүүлэн төлөвлөх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого, зардал тайлагнаагүй	2	39,075.8	2	39,075.8			2	39,075.8		
Үндсэн хөрөнгийг бүртгээгүй	1	237,112.1	1	237,112.1			1	237,112.1		
Гарзыг буруу бүртгэсэн.	1	21,850.3			1	21,850.3	1	21,850.3		
ББӨ илүү бүртгэсэн.	1	40,374.0			1	40,374.0	1	40,374.0		
Бараа материалын үлдэгдлийг буруу тайлагнасан.	1	9,601.2			1	9,601.2	1	9,601.2		
Өр авлагыг зөрүүтэй бүртгэсэн.	2	6,323.6			2	6,323.6	2	6,323.6		
Дүн	8	354,337.0	3	276,187.9	5	78,149.1	8	354,337.0		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Татварын бүртгэлд зөрүүтэй бүртгэсэн.	1	-					1	-					
Шатахууны норм хэтрүүлсэн	1	1,411.4	1	1,411.4									
Анхан шатны баримтгүй болон зориулалт бусаар зарцуулсан	5	20,717.3	5	20,717.3									
Үнэлгээний хорооны гишүүдэд урамшуулал олгосон	1	1,100.0	1	1,100.0									
Дотоод хяналт хангалтгүй	1	-					1	-					
Дансны код буруу	1	-					1	-					
Ухаалаг тоолуурт тавих хяналт хангалтгүй	1	141,680.0			1	141,680.0							
Зөрүүгийн тайлан бэлтгээгүй.	1	-			1	-							
ЗЕХ-ийн 103.1	2	6,707.0	2	6,707.0									
	14	171,615.7	9	29,935.7	2	141,680.0	3	-	-	-	-	-	0

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хамтын гэрээтэй холбоотой	2	-			1		1	
Бүтэц зохион байгуулалттай холбоотой	2	-					2	
ТУЗ-ийн тэмдэглэл байхгүй.	1	-					1	
ХАА-тай холбоотой	3	365,373.0			1	365,373.0	2	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>365,373.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>365,373.0</b>	<b>6</b>	<b>0</b>